



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймаг дахь Хөдөө аж ахуйн мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн хураангуй тайлан

Аудитын код: ОРА-2023/04/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Эрдэнэт хот 2023 он</p>	<p>Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ц.Нармандах Утас: 70353088 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Б.Буян-Ундрах Утас: 70355805 Цахим хаяг: buyanundrakhb@audit.gov.mn</p> <p>Аудитор: Б.Азжаргал Утас: 70357955 Цахим хаяг: azjargalb@audit.gov.mn</p>
---	---



**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2023.02.14 № 07
танай _____-ны № _____-т

ОРХОН АЙМГИЙН ХӨДӨӨ АЖ
АХУЙН МЭРГЭЖЛИЙН
СУРГАЛТ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН
ТӨВИЙН ЗАХИРАЛ
Ц.ОРХОНЧИМЭГ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймгийн Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон аймгийн Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна. Анхан шатны баримтын бүрдэл хангах, түүнд хяналт хэрэгжүүлсэн байдал нь үр нөлөөгүй байгаа нь гүйцэтгэлийн үе шатанд хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнд илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэлээр илэрч байна.

Аудитын гол асуудал

Орхон аймгийн Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв нь 2022 оны төсвийн жилд Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны сайдын багцаас Боловсрол, шинжлэх ухааны яамны сайдын багцад шилжсэн байна.

Бусад асуудлын хэсэг

2022 оны 04 дүгээр сарын 29-ны өдөр батлагдсан “Төрийн хэмнэлтийн тухай хууль” нь тухайн байгууллагын үйл ажиллагаанд санхүүгийн сахилга батыг мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах, хяналт тавихын зэрэгцээ гарч болох эрсдэлийг төлөвлөгөө, гүйцэтгэлд тусгасан бөгөөд байж болох хувилбарыг түүвэрлэн авч горим сорил хэрэгжүүлсэн.

Тухайн аудитыг хийх явцад аудитын дүгнэлт, тайлантай холбогдуулан аудит гүйцэтгэж буй төрийн аудитын албан хаагчид аливаа этгээдийн нөлөөлөл, мэдээллийн нууцлал, ёс зүйтэй холбоотой холбогдох хуулийн дагуу мэдэгдлүүдийг гарган баталгаажуулсан болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

	Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	97,921,803.78	148,767,966.87
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	4,276,828,387.18	4,529,536,509.36
	Нийт хөрөнгийн дүн	4,374,750,190.96	4,678,304,476.23
	Нийт өр төлбөрийн дүн	4,374,750,190.96	4,678,304,476.23
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	4,374,750,190.96	4,678,304,476.23
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	4,374,750,190.96	4,678,304,476.23
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	1,287,821,312.41	2,002,557,448.92
	Үйл ажиллагааны зардлын дүн	1,388,255,817.17	1,699,003,163.65
	Үйл ажиллагааны үр дүн	(100,434,504.76)	303,554,285.27
	Үйл ажиллагааны бус үр дүн		
	Үйл ажиллагааны нийт үр дүн	(100,434,504.76)	303,554,285.27
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	692,398,984.41	692,398,984.41
	Тайлант оны үр дүн		303,554,285.27
	Эцсийн үлдэгдэл		303,554,285.27
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	1,291,206,345.45	1,707,174,715.00
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	1,291,866,345.45	1,617,544,791.38
	Үйл ажиллагааны ЦМГ	(660,000.00)	89,629,923.62
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	-	(60,430,000.00)
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	(660,000.00)	29,199,923.62
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	(660,000.00)	29,199,923.62
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		1,549,242.73
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,549,242.73	30,749,166.35
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	1,662,465,000.00	1,625,165,603.08
	Урсгал зардал	1,662,465,000.00	1,625,165,603.08
	Хөрөнгийн зардал	0	0
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр		1,662,465,000.00
	Улсын төсвөөс санхүүжих		1,464,051,500.00
	Орон нутгийн төсвөөс		198,413,500.00

Гурав. Аудитын илрүүлэлт

3.1 Төлбөрийн акт:

3.2 Албан шаардлага:

Илрүүлэлт: 2021 онд тэтгэвэрт гарсан албан хаагчид тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмжийг 2022 оны төсвийн жилд олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 7.1-д “төсвийн жил нь тухайн оны 1 дүгээр сарын 01-ний өдөр эхэлж, тухайн оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болно”, 7.6-д “төсвийн жил эхлэхэд төсвийн захирагчийн тухайн төсвийн жилийн батлагдсан төсвийг зарцуулах эрх нь нээгдэнэ”, 16.5.2-д “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар

төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д “анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.6-д “анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна” гэж заасантай нийцэхгүй байна.

3.3 Зөвлөмж

Илрүүлэлт: Төлбөрийн И баримтгүй ажил гүйлгээ хийсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5.1.5-д "хариуцлагатай байх", 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.2-д "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна. 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 347 тоот тушаалын хавсралтаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын 5-д "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм" гэсэн хэсэгтэй нийцэхгүй байна.

Зөвлөмж: Бараа материалын бүртгэлээр тавих хяналтыг сайжруулж анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй баримтаар гүйлгээ хийхгүй байх.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас 3,410,1 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авахдаа гэрээ хэлцэл хийлгүй шилжүүлсэн байна.	1	3,410.0					1	3,410.0				
2021 онд тэтгэвэрт гарсан албан хаагчид тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмжийг 2022 оны төсвийн жилд олгосон байна.	1	6,125.7			1	6,125.7						

Дүн	2	9,535.8			1	6,125.7	1	3,410.0				
-----	---	---------	--	--	---	---------	---	---------	--	--	--	--

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Орхон аймаг дахь Хөдөө аж ахуйн мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв	2	9,535.8			1	6,125.7	1	3,410.0				
Дүн	2	9,535.8			1	6,125.7	1	3,410.0				

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	Орхон аймаг дахь Хөдөө аж ахуйн мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв	1	1			1			
	НИЙТ	1	1			1			

